



**Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт
бичиг болон тогтвортой хөгжлийн зорилго
хоорондын уялдаа, тойм шинжилгээ**

ҮР ДҮН, ДҮГНЭЛТ, САНАЛ ЗӨВЛӨМЖ



НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн тухай

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр нь ядуурал, тэгш бус байдал болон уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй шударга бус байдлыг эцэслэх зорилго бүхий НҮБ-ын тэргүүлэгч байгууллага юм. Бид 170 улс орны мэргэжилтнүүд, түншүүдийнхээ өргөн сүлжээтэй хамтран ажиллаж, улс үндэстнүүдэд хүн төрөлхтөн, дэлхий ертөнцөд зориулагдсан цогц, удаан хугацааны шийдлийг бий болгоход нь тусалдаг.

Энэхүү шинжилгээг НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс хэрэгжүүлж буй "Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх нь төсөл"-ийн хүрээнд боловсруулав.

Тус тайлангийн зохиогчдын зүгээс илэрхийлсэн санал бодолд хамтран оролцогч байгууллагуудын үзэл бодол, бодлогыг тусгаагүй болно. Түүнчлэн, товхимолд багтсан мэдээлэл, өгөгдлийн үнэн зөв байдалд баталгаа гаргахгүй бөгөөд үүнийг ашиглахаас үүдэлтэй ямар нэг үр дагаварт хариуцлага хүлээхгүй юм. Энэхүү баримт бичиг дэх "улс орон" гэсэн нэр томъёог ашиглах, тодорхой нутаг дэвсгэр, газар зүйн бүстэй холбоотой иш татсан мэдээлэл авах, тодорхойлолт гаргахад НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн зүгээс эрх зүйн хувьд болон аль нэг газар нутаг, бүсэд хамаарах ямар нэг санал гаргахгүй болно.

© 2021 Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр

Зохиогчийн эрхийг хуулиар хамгаалсан. 2021 онд хэвлэв.

НҮБХХ-өөс зохих ёсны зөвшөөрөл авсан тохиолдолд тус судалгааг хувийн болон арилжааны бус зорилгоор хэвлэх эсвэл хуулбарлахыг зөвшөөрнө. НҮБХХ-ийн бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр арилжааны зорилгоор худалдах, түгээх, дуурайлган хэвлэхийг хориглоно

Та дараах хаягаар орж тус судалгаатай танилцах боломжтой: <http://mn.undp.org>

Та бидэнтэй дараах хаягаар холбогдож болно:

НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр

НҮБ-ын Байр, Нэгдсэн Үндэстний Гудамж 14

Сүхбаатар дүүрэг, 14201

Улаанбаатар хот, Монгол Улс

Утас: + 976-11-327585



ГАРЧИГ

ТАЛАРХАЛ.....	4
ӨМНӨТГӨЛ.....	4
АРГАЧЛАЛ.....	6
ГОЛ ҮР ДҮН, ДҮГНЭЛТ.....	11
АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ	22

ХАВСРАЛТ

ХАВСРАЛТ А. Үндэсний хөгжлийн бодлогын баримт бичиг болон ТХЗ хоорондын уялдааны шинжилгээ	23
ХАВСРАЛТ В. Тогтвортой хөгжлийн зорилго болон Алсын хараа 2050 хоорондын уялдаа	28
ХАВСРАЛТ С. Тогтвортой хөгжлийн зорилго болон Алсын хараа 2050 хоорондын уялдаа	33
ХАВСРАЛТ D. Тогтвортой хөгжлийн зорилго болон Алсын хараа 2050 хоорондын уялдаа, салбар хоорондын төлөвлөлт	38

ХҮСНЭГТ

Хүснэгт 1. Уялдааны шинжилгээ хийсэн загвар хүснэгт	8
Хүснэгт 2. Харьцуулж шинжилсэн хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн товч мэдээлэл.....	9
Хүснэгт 3. Уялдааны шинжилгээний ангилал.....	10
Хүснэгт 4. Уялдааны шинжилгээний үр дүн	10
Хүснэгт 5. Үндэсний хөгжлийн бодлогын баримт бичиг болон ТХЗ хоорондын зорилтын уялдаа	11
Хүснэгт 6. Тогтвортой хөгжлийн зорилтууд болон Алсын хараа 2050-ын хоорондын зорилго, зорилтуудын уялдаа	13
Хүснэгт 7. Үндэсний хөгжлийн бодлогын баримт бичиг болон ТХЗ хоорондын шалгуур үзүүлэлтүүдийн уялдаа	17
Хүснэгт 8. Алсын хараа 2050, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл болон ТХЗ хоорондын шалгуур үзүүлэлтийн уялдаа.....	17
Хүснэгт 9. Үндэсний хөгжлийн бодлогын баримт бичиг болон ТХЗ хоорондын шалгуур үзүүлэлтийн уялдаа.....	18

ЗУРАГ

Зураг 1. Тогтвортой хөгжлийн зорилтууд Алсын хараа 2050-д туссан байдал	12
Зураг 2. Тогтвортой хөгжлийн 11.4 дэх зорилтын уялдаатай салбарууд.....	16
Зураг 3. Шалгуур үзүүлэлтийн бэлэн байдал	17





ТАЛАРХАЛ

Энэхүү товхимолыг боловсруулахад туслалцаа үзүүлж, оролцсон бүх хүмүүстээ баярлалаа.

Ялангуяа чиглэл өгч, хамтран ажилласан Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Зохихсүрэн болон багийн ахлагч Б.Дэлгэрмаа, дотоодын зөвлөх М.Эрдэнэбаяр, Д.Намхайдагва, НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн эдийн засагч асан Т.Дэлгэрнаран, түүнчлэн энэхүү уялдааны шинжилгээг боловсронгуй болгоход үнэтэй зөвлөгөө өгсөн Монгол Улс дахь НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн Орлогч Суурин төлөөлөгч хатагтай Нашида Саттар нарт талархал илэрхийлье.

Түүнчлэн, Нэгдсэн Үндэстний байгууллагын Хөгжлийн хөтөлбөрийн ажилтнууд Л.Бархас, Б.Мөнхтуул, Д.Баасанхүү, Г. Уянга, ноён Бишва Нат Тивари, П.Жаргалсайхан нар техникийн зөвлөгөөгөөр хангаж ирснийг цохон тэмдэглэж байна. Чин сэтгэлийн талархал илэрхийлье.

ӨМНӨТГӨЛ

Нэгдсэн Үндэстний байгууллага (НҮБ)-ын Ерөнхий Ассамблейн 2015 оны чуулганаар 2030 он хүртэлх тогтвортой хөгжлийн 17 зорилго, 169 зорилт батлагдаж, дэлхий нийтээр энэхүү зорилго, зорилтыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Энэхүү зорилтууд нь “хэнийг ч үл орхих” гэсэн зарчимтай бөгөөд байгаль орчин, эх дэлхийгээ хайрлан хамгаалж, хүний эрхийг дээдлэн, байгалийн нөөцийг зохистой ашиглаж, хөгжил цэцэглэлийг бий болгож, нийгэм, эдийн засаг зэрэг бүх салбарыг тэгш хөгжүүлэхэд чиглэгдсэн.

Монгол Улсын Засгийн газар тогтвортой хөгжлийн зорилго (ТХЗ)-д чухал ач холбогдол өгч, санаачилгатай ажиллаж, тодорхой алхамуудыг авсаар ирлээ. Монгол Улсын Их хурал 2016 оны 2 дугаар сард тогтвортой хөгжлийн тодорхой тооны зорилго, зорилтыг агуулсан, Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030-ыг баталсан. Тогтвортой хөгжлийн зорилго болон Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030-ыг хэрэгжүүлэх, түүнд хүрэх эсэх нь туйлын хүндрэлтэй байсан юм. Тийм учраас өнгөрсөн хугацаан дахь ололт, амжилт, алдаа оноонд үндэслэн бодлого төлөвлөлт, хэрэгжилт, хяналт шинжилгээний тогтолцоог илүү боловсронгуй болгох үүднээс Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль 2020 оны 5 дугаар сарын 7-ны өдөр батлагдсан байна. Үүнд, төлөвлөлтөд баримтлах зарчим, санхүүжилт, шалгуур үзүүлэлт, төлөвлөлтийн харилцаанд оролцогчдын эрх, үүрэг болон





удирдлага, зохион байгуулалтыг тодорхой болгосон олон ач холбогдолтой зохицуулалтуудыг тусгасан.

Энэхүү хууль эрх зүйн өөрчлөлтөөр болон Монгол Улсын Их хурлын 2020 оны 5 дугаар сарын 7-ны өдрийн 45 дугаар тогтоолоор Монгол Улсын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүд харилцан уялдаатай байхаар заасан. Иймд, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах нийтлэг журамд зохих өөрчлөлтийг оруулаад байна. Шинэчлэгдсэн хууль эрх зүйн хүрээнд Монгол Улсын Их Хурал хөгжлийн стратегийн чиглэлүүдийг шинэчлэн тодорхойлж, 2050 он хүртэлх урт хугацааны тогтвортой хөгжлийн үзэл баримтлал болох Алсын харааг баталсан. Эл урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт үндэслэж, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл болон Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг мөн тус тус боловсруулан батлуулаад байна.



Алсын хараа 2050. Монгол Улсын Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого гэдгийг “Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлэх, дэлхий нийтийн хөгжлийн түгээмэл хандлагыг өөрийн орны онцлогт тохируулан тусгасан, байгаль орчны тэнцвэрт байдлыг хадгалах, хүний хөгжлийг хангах, эдийн засаг, нийгэм, засаглалын хөгжлийг ахисан түвшинд хүргэхэд чиглэсэн урт хугацааны зорилго, зорилт, хүрэх үр дүн, үйл ажиллагаа, шалгуур үзүүлэлтийг тусгасан баримт бичиг” гэж тодорхойлсон. Энэ суурь, зарчмын хүрээнд хүний хөгжил, засаглал, эдийн засаг, нийгмийн

хөгжлийн тэргүүлэх чиглэлтэй, нийт есөн хөгжлийн зорилгыг тодорхойлж, 2050 он гэхэд Монгол Улс нийгмийн хөгжил, эдийн засгийн өсөлт, иргэдийн амьдралын чанараар Азид тэргүүлэгч орнуудын нэг болно гэсэн зорилтыг дэвшүүлээд байна.

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл. Тус баримт бичиг нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн, хөгжлийн зорилтот хөтөлбөрт нийцүүлсэн улс, салбар, салбар хооронд болон бүс, орон нутгийн уялдааг хангасан зорилго, зорилт, хүрэх үр дүн, санхүүгийн эх үүсвэрийг нарийвчлан төлөвлөсөн үйл ажиллагаа, тоон болон чанарын шалгуур үзүүлэлт бүхий дунд хугацааны нэгдсэн төлөвлөлтийн баримт бичиг юм.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгагдсан зорилго, зорилтод нийцсэн, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд чиглэсэн төлөвлөлтийн баримт бичиг юм. Үүнийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө буюу Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2020 оны 12 дугаар сард батлаад байна.




Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд орсон өөрчлөлтөөр Засгийн газрын Хэрэг эрхлэх газар нь хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудлыг Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болох Үндэсний хөгжлийн газрын оролцоотойгоор урт хугацааны хөгжлийг зорилтыг хангахад чиглэсэн бодлого төлөвлөлтийн тогтолцоог бүрдүүлэх, урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогыг төлөвлөх, боловсруулах, дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх асуудлыг хариуцдаг.

Иймд, Монгол Улсын Засгийн газар Хэрэг эрхлэх газар Нэгдсэн Үндэстний байгууллагын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран одоогийн батлагдсан урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт анализ хийж, тогтвортой хөгжлийн зорилготой хэрхэн уялдаж байгаа талаар шинжилгээ хийхийг зорьсон. Уялдааны шинжилгээг хийснээр хөгжлийн бодлого төлөвлөлтөд анализ хийж, анхаарах асуудлыг тодорхойлж, төлөвлөлтийн зөрүүг арилгах, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг тогтвортой хөгжлийн зорилготой уялдуулахад чухал ач холбогдолтой.





АРГАЧЛАЛ



Уялдааны шинжилгээний гол зорилго нь 2020 онд шинээр батлагдсан дээр дурдсан үрт болон дүнд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг буюу Алсын хараа 2050 үрт хугацааны бодлогын баримт бичгийн I үе шат, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон тогтвортой хөгжлийн зорилго хоорондын зорилт, шалгуур үзүүлэлтүүдийн уялдааг тодорхойлоход оршино. Уялдааг НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс гаргасан Түргэвчилсэн нэгдсэн үнэлгээний аргачлал¹-д тулгуурлан боловсруулав. Уялдааны шинжилгээ нь тогтвортой хөгжлийн зорилго болон үндэсний хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн уялдаа, хамаарлыг тодорхойлж, төлөвлөлтийн зөрүүг арилгах, тэнцвэртэй байдлыг хангах, тогтвортой хөгжлийн зорилгыг улс орны түвшинд, салбарын түвшинд, цаашлаад орон нутгийн түвшинд хэрэгжүүлэхэд ихээхэн ач холбогдолтой.

Түргэвчилсэн нэгдсэн үнэлгээний аргачлал нь тогтвортой хөгжлийн зорилгыг хэрэгжүүлэх хамгийн чухал суурь алхам юм. Улс орнууд тогтвортой хөгжлийн зорилтыг хангахад чиглэсэн бодлого, стратегийн төлөвлөлтийг бий болгох, төлөвлөлтөө нийцүүлэх болон үр ашигтай төлөвлөлтийг бий болгох зэрэг өргөн бололцоог энэхүү аргачлал олгодог. Өөрөөр хэлбэл, тус

аргачлалыг ашигласнаар, үндэсний түвшинд, салбарын түвшинд мөн түүнчлэн орон нутгийн түвшин дэх зорилт, шалгуур үзүүлэлтийн уялдаа, хамаарал, зорилтуудыг хэрэгжүүлэх байгууллага, үнэлгээний систем зэрэг дэлгэрэнгүй мэдээллүүд нарийвчлан тодорхойлогддог.

Гэхдээ, энэхүү шинжилгээ нь Түргэвчилсэн нэгдсэн үнэлгээний аргачлалын **эхний үе шат** болох уялдааны шинжилгээнд **зөвхөн** төвлөрч, тогтвортой хөгжлийн зорилгууд болон үндэсний хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн хооронд уялдааг судлахад зорьсон болно. Тодруулбал, 2020 оны 12 дугаар сард шинэчлэн батлагдсан хууль эрх зүйн орчны хүрээнд боловсруулсан хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд уялдааны шинжилгээг хийсэн болно. Шинжилгээний дэлгэрэнгүй үр дүнг **Хавсралт А**-д үзүүлэв.

Тогтвортой хөгжлийн зорилгуудыг хэрэгжүүлэх институцийн чадавх, хоорондын уялдаа холбоо, хяналт-шинжилгээ үнэлгээ, мэдээллийн бэлэн байдал зэрэгт хийсэн үнэлгээнүүд сүүлийн жилүүдэд хийсэн. Тодруулбал, Азийн хөгжлийн банк, Нэгдсэн Үндэстний байгууллага хамтран гаргасан Тогтвортой хөгжлийн зорилгуудын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар бодлогын зөвлөгөө өгөх хамтарсан тайлан,² Монгол Улсын

¹ UNDP. 2017. Rapid Integrated Assessment (RIA) to facilitate mainstreaming of SDGs into national and local plans, New York.


² НҮБ, АХБ, (2018). Тогтвортой хөгжлийн зорилгуудын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар бодлогын зөвлөгөө өгөх хамтарсан ажлын тайлан, Улаанбаатар.



Үндэсний сайн дурын илтгэл, Монгол Улсын цахим өгөгдлийн орчны зураглал ба үнэлгээ зэрэг юм. Эдгээр судалгаанд хийгдсэн ажлуудыг дахин давтахгүйн тулд зөвхөн ТХ-ийн зорилгууд, зорилтууд, шалгуур үзүүлэлтүүдтэй шинээр батлагдсан

хөгжлийн бодлогын гурван баримт бичгүүдийн хоорондын уялдааг үнэлсэн юм. Энэхүү шинжилгээнд ашигласан загвар нь олон улсад танигдсан загвар бөгөөд үүнийг Хүснэгт 1-ээр харуулав.

ХҮСНЭГТ 1. Уялдааны шинжилгээ хийсэн загвар хүснэгт

Тогтвортой хөгжлийн зорилгууд, зорилтууд	Хөгжлийн бодлогын зорилтыг хэрэгжүүлэх гол салбар	Үндэсний урт хугацааны хөгжлийн бодлого	Үндэсний дунд хугацааны хөгжлийн бодлого	Салбарын төлөвлөгөө	Тухайн зорилтын хэрэгжилтийг хэмжих үндэсний шалгуур үзүүлэлт	ТХ-ийн зорилгууд, зорилтууд, шалгуур үзүүлэлтүүдийг үндэсний зорилго, зорилт, шалгуур үзүүлэлтүүдтэй харьцуулна.
		ТХЗ-ын асуудлуудыг тусгасан хамгийн ойролцоо утга, агуулгатай зорилго, зорилтыг тус бүр ялгаж, тодорхойлно	ТХЗ-ын асуудлуудыг тусгасан хамгийн ойролцоо утга, агуулгатай зорилго, зорилтыг тус бүр ялгаж, тодорхойлно.	ТХЗ-ын асуудлуудыг тусгасан хамгийн ойролцоо утга, агуулгатай зорилго, зорилтыг тус бүр ялгаж, тодорхойлно.		Үндэсний хөгжлийн зорилго, зорилт нь ТХЗ-той уялдаатай байна уу? (Тийм/Үгүй)
						
Зорилго 1: Ядуурлын бүх хэлбэрийг эцэс болгох						
Зорилт 1.1 2030 он гэхэд өдөрт 1.25 ам.доллараас бага орлоготой гэж одоогоор тооцогдож буй хүмүүсийн туйлын ядуурлыг арилгах						

Уялдааны шинжилгээний хамрах хүрээг Тогтвортой хөгжлийн зорилго (17 зорилго), зорилт (169 зорилт) болон Алсын хараа 2050 буюу Монгол Улсын урт хугацааны хөгжлийн баримт бичгийн 2021-2030 онд хэрэгжүүлэх I үе шат, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл,

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр гэж тодорхойлов. Эдгээр баримт бичгүүдэд тодорхойлсон зорилго, зорилт, шалгуур үзүүлэлтийн товч мэдээллийг Хүснэгт 2-оор харуулав.



ХҮСНЭГТ 2. Харьцуулж шинжилсэн хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн

ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

	Алсын хараа 2030	Монгол Улсыг 2021- 2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	Тогтвортой хөгжлийн зорилгууд
Батлагдсан огноо	2020.05.13	2020.08.28	2020.12.09	2015.09.25
Зорилго	9	9	23	17
Зорилт	47 (Дэд:965)	47 (Дэд:243)	259 (Дэд:956)	169
Шалгуур үзүүлэлт	73	95	203	244

Судалгааг хийхдээ, хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн (i) **зорилго, зорилт** болон (ii) **шалгуур үзүүлэлтүүдийн** үндсэн санаа, агуулга, утга найруулга, бүтэцтэй танилцаж, тогтвортой хөгжлийн зорилготой харьцуулж, давхцал, нийцэл, уялдаатай байдлыг үнэлж, боловсруулалт, дүн шинжилгээг хийж, холбогдох байгууллагуудаас санал авч, үр дүнг гаргасан болно. Үүнд, дараах дарааллыг баримтлав.

- Тогтвортой хөгжлийн 17 зорилго, 169 зорилт, 244 шалгуур үзүүлэлтүүдийг дор дурдсан үндэсний хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн зорилго, зорилт, шалгуур үзүүлэлтүүдтэй нэг бүрчлэн ойролцоо уялдаатай байдлаар нь зэрэгцүүлэв.

(i) Алсын хараа 2030;

(ii) Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл;

(iii) ЗГ-ын 2020-2024 онд үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө.

- Тогтвортой хөгжлийн зорилгод тусгагдсан асуудлуудад хамгийн ойролцоо утга, агуулгатай Үндэсний зорилго, зорилт, шалгуур үзүүлэлтүүдийг харьцуулав. Үүнд, дараах гол асуултуудыг тавих замаар ялгаж ангилав.

(i) Тогтвортой хөгжлийн зорилт, шалгуур үзүүлэлт бүрэн агуулагдсан байна уу?

(ii) Тогтвортой хөгжлийн зорилт, шалгуур үзүүлэлт хэрэгжсэн байна уу?

(iii) Тогтвортой хөгжлийн зорилт, шалгуур үзүүлэлт хамааралтай байна уу, уялдсан байна уу?

(iv) Хэрэв уялдсан бол бүрэн уялдсан уу, агуулгаараа уялдсан байна уу?

Шинжилгээний явцад дараах зүйлс ажиглагдав. Тухайлбал,

- 17 дугаар зорилго буюу дэлхийн нийтийн хөгжлийн түншлэл, механизмтай холбоотой зарим зорилтууд нь ихэвчлэн өндөр хөгжилтэй оронд хамааралтай, хөгжиж буй Монгол улсын хувьд төдийлөн хамааралгүй байдаг. Тиймээс энэ уялдааны шинжилгээнд эдгээр зорилтуудыг тусад нь авч үзэв.
- 14 дүгээр зорилго буюу далай, тэнгистэй холбоотой ихэнх зорилтууд нь далайд гарцгүй, хуурай газраар хүрээлэгдсэн манай оронд бас хамааралгүй.
- Монгол улсад аль хэдийн хэрэгжээд дууссан зорилтууд тогтвортой хөгжлийн зорилтод агуулагдсан байна.



Уялдааны шинжилгээг хийхдээ ТХЗ-үүдэн зорилтууд, шалгуур үзүүлэлтүүдийг сонгож авсан хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдсан байдлаар нь дараах байдлаар ангилав.

ХҮСНЭГТ 3. Уялдааны шинжилгээний ангилал

Уялдаатай	Агуулгаараа уялдаатай	Уялдаагүй	Манай оронд хамааралгүй	Бүрэн хэрэгжсэн ³
1	2	3	4	5
Монгол Улсын зорилго, зорилт нь тогтвортой хөгжлийн зорилтын хамрах хүрээ, хүрэх түвшинтэй үг үсэг, утга агуулгын хувьд уялдаатай, нийцэлтэй;	Монгол Улсын зорилго, зорилт нь тогтвортой хөгжлийн зорилтын хамрах хүрээ, хүрэх түвшинтэй үг үсэг, утга агуулгын хувьд аль нэг нь тодорхой хэмжээгээр нийцэж, агуулгын уялдаатай.	Монгол Улсын зорилго, зорилт нь тогтвортой хөгжлийн зорилттой уялдаагүй;	Тогтвортой хөгжлийн зорилт нь Монгол Улсын бодлого, зорилттой хамаарахгүй.	Тогтвортой хөгжлийн зорилт нь Монгол Улсад хэрэгжсэн, дахиж зорилт болгон тодорхойлох шаардлагагүй.

Шинжилгээг Хүснэгт 4-ын дагуу (а) зорилго, зорилт хоорондын уялдаа болон (b) шалгуур үзүүлэлт хоорондын уялдаа гэсэн байдлаар ангилж, дэлгэрэнгүй хүснэгт үүсгэж, дүгнэлтийг гаргасан болно.

ХҮСНЭГТ 4. Уялдааны шинжилгээний үр дүн

Тогтвортой хөгжлийн зорилго	Алсын хараа 2050	Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	МУЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө
1	2	3	4
169 (зорилт)	965(зорилт)	243 (зорилт)	956 (зорилт)
Зорилт 1.1 2030 он гэхэд өдөрт 1.25 ам.доллараас бага орлоготой гэж одоогоор тооцогдож буй хүмүүсийн туйлын ядуурлыг арилгах.			
244 (шалгуур үзүүлэлт)	73 (шалгуур үзүүлэлт)	95 (шалгуур үзүүлэлт)	203 (шалгуур үзүүлэлт)
1.1.1. Ядуурлын олон улсын түвшнээс доогуур амьдралтай хүн амын эзлэх хувь, хүйсээр, насны бүлгээр, ажил эрхлэлтийн байдлаар, байршлаар /хот, орон нутгаар/			

³Энэ үзүүлэлт нь НҮБ-ын аргачлалд дурдагдаагүй үзүүлэлт бөгөөд Монгол Улсын нөхцөлд нийцүүлж, нэмж тодорхойлов.



ГОЛ ҮР ДҮН, ДҮГНЭЛТ



Сонгож авсан Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн тухайд, тэдгээр нь тогтвортой хөгжлийн зорилготой зорилтын хувьд **сайн** уялдаатай, харин тэдгээрийн шалгуур үзүүлэлтүүд хоорондоо **хангалтгүй** уялдаатай байна.

Үндэсний хөгжлийн бодлогын баримт бичиг болон ТХЗ хоорондын зорилтын уялдаа

Уялдааны түвшин

Тогтвортой хөгжлийн зорилгын 169 зорилтууд болон 244 шалгуур үзүүлэлтүүдийг бүхэлд нь судалж, шинжилсэн болно. Тогтвортой хөгжлийн 169 зорилтууд болон сонгож авсан үндэсний хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн зорилго, зорилтууд хоорондын хамаарлыг судлахад, тогтвортой хөгжлийн 169 зорилтуудын 104-116 зорилт нь бүрэн уялдаатай, 24-27 зорилт нь агуулгаараа уялдаатай, 11-21 зорилт нь уялдаагүй, 13 зорилт нь хамааралгүй, 4 зорилт нь бүрэн хэрэгжсэн гэж дүгнэгдсэн байна. Шинжилгээний хураангуй үр дүнг Хүснэгт 5-аар харуулав.

ХҮСНЭГТ 5. Үндэсний хөгжлийн бодлогын баримт бичиг болон ТХЗ хоорондын зорилтын уялдаа

	Уялдаатай	Агуулгаараа уялдаатай	Уялдаагүй	Хамааралгүй	Бүрэн хэрэгжсэн
Алсын хараа 2050	116	24	12	13	4
Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	104	27	21	13	4
МУЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	111	26	15	13	4

Тогтвортой хөгжлийн 17 зорилгын зорилт тус бүрийг сонгож авсан Үндэсний хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн зорилттой зэрэгцүүлж ангилсан дэлгэрэнгүй үр дүнг **Хавсралт А**-ээр үзүүлэв. Дэлгэрэнгүй шинжилгээний үр дүнд үндэслэн дараах дүгнэлтийг танилцуулав байна.

- Аль ч үндэсний хөгжлийн бодлогын баримт бичигтэй үг үсэг болон утга агуулгын хувьд огт уялдаагүй тогтвортой хөгжлийн дараах зорилтууд байна.



Тэдгээрийг дурдвал, ТХЗ 10.с, ТХЗ 13.3, ТХЗ 14.4, ТХЗ 15.7, ТХЗ 15.8, ТХЗ 17.18, ТХЗ 17.19.

- Зарим зорилтуудын тухайд урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг буюу Алсын хараа 2050-тай уялдсан хэдий ч тэдгээр нь дунд хугацааны баримт бичиг (Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, МУЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр)-тэй огт уялдаагүй байна. Жишээ нь: ТХЗ 10.7, ТХЗ 11.b, ТХЗ 11.с, ТХЗ 12.6, ТХЗ 12.8, ТХЗ 12.с, ТХЗ 15.с, ТХЗ 16.a.
- ТХЗ 3.6, ТХЗ 5.5, ТХЗ 8.8, ТХЗ 9.a, ТХЗ 12.1, ТХЗ 15.b, ТХЗ 17.15, ТХЗ 17.16 эдгээр зорилтуудын тухайд, Алсын хараа-д агуулгаараа уялдаатай тусгагдсан хэдий ч дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг буюу Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, МУЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй илүү сайн уялдаж тусгагдсан байна. Жишээ нь: ТХЗ 3.6 таван жилийн үндсэн чиглэлд бүрэн уялдсан бол Алсын хараа 2050-д агуулгаараа уялдсан байна.

Алсын хараа 2050

Алсын хараа 2050 нь ТХЗ-үүдтай уялдаатай байна. Тэдгээрийн зорилтууд хоорондын уялдааны шинжилгээний үр дүнгээс харахад, тогтвортой хөгжлийн нийт 169 зорилтын 116 зорилт нь Алсын хараа 2050-тай бүрэн уялдаатай, 24 зорилттой нь агуулгаараа уялдаатай, 12 зорилт нь огт тусаагүй, 13 зорилт нь манай оронд шүүд хамааралгүй, 4 зорилт нь бүрэн хэрэгжсэн байна гэж дүгнэгдсэн. Зураг 1-т уялдааны үр дүнг зураглалаар үзүүлэв. Тогтвортой хөгжлийн зорилго болон Алсын хараа 2050-ын зорилгууд хоорондын уялдааг харуулсан үр дүнгийн дэлгэрэнгүйг Хавсралт В, С-ээс үзнэ үү.

ЗУРАГ 1. Тогтвортой хөгжлийн зорилтууд Алсын хараа 2050-д туссан байдал





ХҮСНЭГТ 6. Тогтвортой хөгжлийн зорилтууд болон Алсын хараа 2050-ын хоорондын зорилго, зорилтуудын уялдаа

Тогтвортой хөгжлийн зорилго	Тогтвортой хөгжлийн зорилт	Уялдаатай зорилт
Ядуурлыг устгах	7	6
Өлсгөлөнг зогсоох	8	8
Эрүүл мэндийг дэмжих	13	11
Чанартай боловсролыг дэмжих	10	9
Жендэрийн эрх тэгш байдлыг хангах	9	5
Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах	8	7
Сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх	5	5
Эдийн засгийн өсөлт, баталгаат ажлын байрыг бий болгох	12	9
Инновац болон дэд бүтцийг хөгжүүлэх	8	7
Тэгш бус байдлыг бууруулах	10	8
Ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих	10	6
Хариуцлагатай хэрэглээг дэмжих	11	9
Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг бууруулах	5	3
Далай, тэнгисийн нөөцийг хамгаалах	10	0
Хуурай газрын эко системийг хамгаалах	12	6
Энх тайван, шударга ёсыг цогцлоох	12	10
Хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх	19	7

Тогтвортой хөгжлийн зорилго болон Алсын хараа 2050-ын хоорондын зорилго, зорилтуудын уялдааг Хүснэгт 6-аар харуулав. ТХЗ 2:Өлсгөлөнг зогсоох, ТХЗ 4:Чанартай боловсролыг дэмжих, ТХЗ 7:Сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх гэсэн зорилгууд бүрэн уялдаатай байхад ТХЗ 5:Жендэрийн эрх тэгш байдлыг хангах, ТХЗ 15: Хуурай газрын эко системийг хамгаалах, ТХЗ 17: Хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх зорилго хангалтгүй уялдаатай байна. Тэдгээр хангалтгүй уялдаатай зорилгыг улаан өнгөөр тэмдэглэв. Эдгээр зорилтуудыг цаашид нэг бүрчлэн нягтлан судалж, уялдаагүй гэж ангилагдсан шалтгааныг тодорхойлж, дараа дараагийн батлагдах дүнд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгах талаар анхаарах нь зүйтэй юм.

Тогтвортой хөгжлийн зорилго болон Алсын хараа 2050 хоорондоо бүрэн уялдсан **2 бүлэг зорилго** байна.

- ТХЗ 2: Өлсгөлөнг зогсоох
- ТХЗ 7: Сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх



ТХЗ 2: Өлсгөлөнг
зогсоох



ТХЗ 7: Сэргээгдэх эрчим
хүчийг нэвтрүүлэх

Тогтвортой хөгжлийн зорилго болон Алсын хараа 2050 хоорондоо уялдаагүй гэж ангилагдсан дор дурдсан зорилго, зорилтууд байна.



ТХЗ 8.8: Хөдөлмөрлөх
эрхийг хамгаалах,
аюулгүй ажиллах орчин



ТХЗ 10.с: Мөнгөн гуйвуулгын
гүйлгээний шимтгэл



ТХЗ 12.1: Тогтвортой хэрэглээ,
үйлдвэрлэлийн бодлого



ТХЗ 17.15: Бодлогын орон зай,
манлайллыг хүндэтгэх
ТХЗ 17.16: ТХЗ-д хүрэх хамтын
ажиллагаа
ТХЗ 17.18: Найдвартай тоо,
статистик мэдээллийн хүртээмж
ТХЗ 17.19: Статистикийн чадавх



ТХЗ 13.3: Цаг уурын
өөрчлөлтийн нөлөөллийг
бууруулах, урьдчилан
сэрэмжлүүлэх



ТХЗ 14.4: Тогтвортой
загас агнуур



ТХЗ 15.7: Ургамлын болон
амьтны хулгайн ан
ТХЗ 15.8: Өөр гарагийн
үржихүйц төрөл зүйлийг
нутагшуулахаас сэргийлэх
ТХЗ 15.b: Ойн тогтвортой
менежментийн санхүүжилт

Тайлбар: ТХЗ 8.8, ТХЗ 12.1, ТХЗ 15.b, ТХЗ 17.15, ТХЗ 17.16 эдгээр зорилтын тухайд хэдийгээр Алсын хараа 2050-тай огт уялдаагүй ч, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй агуулгаараа уялдаатай.

Тогтвортой хөгжлийн зорилго болон Алсын хараа 2050 хоорондоо агуулгаараа уялдаатай дараах зорилтууд байна. Эдгээр зорилтуудын орхигдсон зорилт, хүрэх түвшин, хүрээ, шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, учир шалтгааныг судалж, дараа дараагийн батлагдах дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт гүйцээж, тусгах боломжийг судлах нь зүйтэй.



1b Ядуурлыг арилгах олон талын бодлого

3.6 Авто замын хөдөлгөөний осол

4.6 Насанд хүрэгчдийн бичиг үсэг, тооны мэдлэг

5.5 Эмэгтэйчүүдийн манлайлал
5.a Эмэгтэйчүүдийн эдийн засгийн тэгш эрх
5.c Жендэрийн тэгш байдал

6.5 Хил дамнансан усны нөөцийн менежмент

8.5 Бүтээмжтэй ажил, хөдөлмөр эрхлэлт
8.b Залуучуудыг дэмжсэн ажил эрхлэлтийн стратеги

9.a Уян хатан дэд бүтцийн хөгжил

10.6 Үр дүнтэй, хариуцлагатай засаглал



11.3 Хүн амын хотжилтын тогтвортой төлөвлөлт

11.b Гамшгийн эрсдэлийн цогц менежмент

11.c Орон нутгийн материалыг ашиглан даац сайтай, тэсвэртэй, эдийн засгийн хэмнэлттэй барилга байгууламж



12.6 Аж ахуй нэгж, компаниудын тогтвортой байдал



13.b Цаг уурын өөрчлөлттэй холбоотой үр дүнтэй төлөвлөлт, менежмент



15.6 Генетик нөөц баялгийн ашиглалт
15.a Биологийн олон янз байдал, экосистемийг хамгаалах санхүүжилт
15.c Хамгаалагдсан төрөл зүйлийн хууль бус ан



16.8 Засаглалын үйл ажиллагаа



17.1 Татвар, бусад орлого бүрдүүлэх үндэсний чадавх
17.9 Тогтвортой хөгжлийн зорилгыг хэрэгжүүлэх чадавх
17.14 Тогтвортой хөгжлийн бодлогын уялдаа, холбоо


Салбар хоорондын уялдаа

Тогтвортой хөгжлийн зорилго болон Алсын хараа 2050 хоорондын уялдааны шинжилгээний үр дүнгийн дэлгэрэнгүйг **Хавсралт D**-д үзүүлэв. Энэхүү үр дүнгээс салбар хоорондын шинжтэй зорилтуудыг тодорхой харж болно. Өөрөөр хэлбэл, хэд хэдэн бүлэгт тэмдэглэгээ (бүрэн уялдаатай, агуулгаараа уялдаатай)-тэй байгаа зорилтуудыг салбар хооронд төлөвлөгдсөн зорилт гэж үзэж болно. Үүнээс, тогтвортой хөгжлийн 169 зорилтуудын ихэнх буюу 70% нь салбар хооронд тодорхойлогдсон байгааг тодорхой харж байна. Тодруулбал, тогтвортой хөгжлийн 29 зорилт нь Алсын хараа 2050-ын 3 зорилттой, тогтвортой хөгжлийн 27 зорилт нь Алсын хараа 2050-ын 4 буюу түүнээс дээш зорилттой харилцан уялдаатай байна.



Жишээ нь, **ТХЗ 11.4** буюу Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хадгалан хамгаалах арга хэмжээг сайжруулах зорилт нь хэд хэдэн ялгаатай салбар буюу соёл, байгаль орчин, аялал жуулчлал, боловсрол, дэд бүтцийн салбаруудын хамтын оролцоотойгоор хэрэгжихээр төлөвлөгдсөн байна. Иймд, тогтвортой хөгжлийн зорилгыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд **салбар хоорондын зохицуулалт, нэгдсэн чиглэл** ихээхэн ач холбогдолтой.

ЗУРАГ 2. Тогтвортой хөгжлийн 11.4 дэхь зорилтын уялдаатай салбарууд



Үндэсний хөгжлийн бодлогын баримт бичиг болон ТХЗ-уудын шалгуур үзүүлэлт хоорондын уялдаа

Тогтвортой хөгжлийн зорилгын 244 шалгуур үзүүлэлтүүдийн дөнгөж **8%** буюу **20** шалгуур үзүүлэлт нь сонгож авсан хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдаатай гэж дүгнэгдсэн байна. Манай оронд тооцох боломжгүй **100** шалгуур үзүүлэлт байна. Тэдгээрийг цаашид гүнзгийрүүлэн судалж, учир шалтгааныг тодорхойлж, түүнд үндэслэж үр дүнтэй шийдлийг гаргах шаардлагатай байна.




Үнэлгээгээр тогтвортой хөгжлийн зорилго болон Алсын хараа 2050, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн шалгуур үзүүлэлт хоорондын уялдааны үр дүн адил үзүүлэлттэй гарсан.

Тогтвортой хөгжлийн зорилго болон сонгож авсан үндэсний хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн шалгуур үзүүлэлтүүдийн уялдааг шинжлэв. Шалгуур үзүүлэлтүүдийн бэлэн байдлыг Зураг 3-аар үзүүлэв. Үүнд, нийт 244 шалгуур үзүүлэлтүүдийн **134 (55%)** шалгуур үзүүлэлтүүдийг дөнгөж манай оронд одоогийн байдлаар тооцох боломжтой байна. Эдгээрийн 18-20 шалгуур үзүүлэлт уялдаатай байна. Гэтэл, **тооцох боломжтой хэдий ч тусгаагүй 114-116 үзүүлэлт байна.** Түүнчлэн, дээр дурдсан **100** шалгуур үзүүлэлтийг манай оронд тооцдоггүй, 10 шалгуур үзүүлэлт



манай оронд хамааралгүй байна. Шалгуур үзүүлэлтийн уялдааны үр дүнг Хүснэгт 7-9-өөр харуулав.

ЗУРАГ 3. Шалгуур үзүүлэлтийн бэлэн байдал




Эх суралж: Статистикийн нэгдсэн мэдээллийн сан, [Http://www.1212.mn](http://www.1212.mn)

ХҮСНЭГТ 7. Үндэсний хөгжлийн бодлогын баримт бичиг болон ТХЗ хоорондын шалгуур үзүүлэлтүүдийн уялдаа


	Уялдаатай	Тооцох боломжтой боловч, уялдаагүй	Хамааралгүй	Тооцох боломжгүй
Алсын хараа 2050	20	114	10	100
Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	20	114	10	100
МУЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	18	116	10	100

ХҮСНЭГТ 8. Алсын хараа 2050, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл болон ТХЗ хоорондын шалгуур үзүүлэлтийн уялдаа





ХҮСНЭГТ 9. Үндэсний хөгжлийн бодлогын баримт бичиг болон ТХЗ хоорондын шалгуур үзүүлэлтийн уялдаа



Тайлбар:

- A** Алсын хараа 2050
- B** Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл
- C** МУЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр
- Бүдэг цэнхэр** ТХЗ-ын нийт шалгуур үзүүлэлт
- Тод цэнхэр** Уялдаатай
- |** Тооцох боломжтой шалгуур үзүүлэлт



Дээрх шалгуур үзүүлэлтүүд хоорондын уялдааны шинжилгээний үр дүнд тодорхой асуудлууд ажиглагдсан. **Эдгээр асуудлуудын үр дүнтэй шийдлийг олох нь тогтвортой хөгжлийн зорилгуудын цаашдын хэрэгжилтийг эрчимжүүлэхэд чухал ач холбогдолтой юм.**

- Тогтвортой хөгжлийн зорилго, зорилтуудын хэрэгжилтийг үнэлэх **үндэсний шалгуур үзүүлэлт, тэдгээрийн сүүр үзүүлэлтийг** тодорхойлох нь нэн чухал юм. Түүнд үндэслэж, тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтийн явц, үнэлгээг гаргаж, мэдээлэх боломж бүрдэнэ. Одоогийн байдлаар Монгол Улсын Засгийн газар тогтвортой хөгжлийн зорилгын үндэсний шалгуур үзүүлэлтүүдийг батлахаар чармайн ажиллаж байна.
- Тогтвортой хөгжлийн зорилт нь улс орнуудын эх дэлхий, хүн бүрийн сайн сайхны төлөөх урт хугацааны хөгжлийн **нийтлэг, цогц** төлөвлөлт юм. Улс орон бүр өөр өөрийн гэсэн онцлогтой, хөгжлийн ялгаатай түвшинтэй, газар нутаг нь харилцан адилгүй тогтоцтой. Тийм учраас зарим шалгуур үзүүлэлтүүд, ялангуяа далай тэнгис, өндөр хөгжилтэй орноос буурай хөгжилтэй орнуудад тусламж дэмжлэг үзүүлэхтэй холбоотой шалгуур үзүүлэлт, зорилтууд Монгол Улсад хамааралгүй байна.
- Тогтвортой хөгжлийн зорилгын ихэнх шалгуур үзүүлэлтүүдийн мэдээллийн эх сурвалж, тооцох аргачлал тодорхойгүй хэвээр байна.
- Дунд хугацааны буюу 10 жилийн хугацаанд хэрэгжих хөгжлийн зорилтот хөтөлбөр 2022 онд батлагдана. Тэдгээр хөгжлийн зорилтот хөтөлбөрүүдэд тогтвортой хөгжлийн шалгуур үзүүлэлтүүдийг аль болох олон тоогоор нэмж тусгана гэсэн хүлээлттэй байна.
- Үндэсний хөгжлийн бодлогын баримт бичиг болон ТХЗ хоорондын шалгуур үзүүлэлтүүдийн уялдаа маш хангалтгүй байна. Иймд, эдгээр шалгуур үзүүлэлтүүдийн ач холбогдлыг ойлгох, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийг салбар хооронд, улсын түвшинд удирдан зохион байгуулах, чиглэлийг илүү **тодорхой болгох**, шалгуур үзүүлэлтүүдийн хэрэгжилтийг мэдээлэх байгууллагуудыг тодорхой болгох зэрэгт анхаарал хандуулах хэрэгтэй.

Дээрх дүгнэлтнээс, одоогийн хяналт-шинжилгээ, үнэлгээ, зохион байгуулалтын системийг үр дүнд суурилсан төлөвлөлт, төсөвлөлт, хяналт, үнэлгээнд чиглүүлэх, хууль эрхзүйн орныг илүү боловсронгуй болгох шаардлагатай нь харагдаж байна.



ЗӨВЛӨМЖ, ДҮГНЭЛТ

Уялдааны тойм шинжилгээний үр дүнд энэхүү зөвлөмжийг гаргав. Эл зөвлөмж буюу санал болгох зүйлүүдийг боловсруулахдаа зөвхөн сонгож авсан гурван хөгжлийн бодлогын баримт бичгийн хүрээнд анализ, шинжилгээ хийж, үр дүнг гаргасан болно.

- Тогтвортой хөгжлийн зорилтуудын ойролцоогоор **80%** нь Алсын хараа 2050, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, мөн Засгийн газрын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдаатай байна.
- Тогтвортой хөгжлийн нийт 169 зорилтын 11-20 зорилт нь Үндэсний хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдаагүй байна (Сонгож авсан баримт бичгийн хүрээнд). Тухайлбал:

ТХЗ 8.8: Хөдөлмөрлөх эрхийг хамгаалах, аюулгүй ажиллах орчин

ТХЗ 10.с: Мөнгөн гуйвуулгын гүйлгээний шимтгэл

ТХЗ 12.1: Хэрэглээ, үйлдвэрлэлийн тогтвортой бодлого

ТХЗ 13.3: Цаг уурын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, урьдчилан сэрэмжлүүлэх

ТХЗ 14.4: Тогтвортой загас агнуур

ТХЗ 15.7: Ургамлын болон амьтны хулгайн ан

ТХЗ 15.8: Өөр гарагийн үржихүйц төрөл зүйлийг нутагшуулахаас сэргийлэх

ТХЗ 15.b: Ойн менежментийн тогтвортой санхүүжилт

ТХЗ 17.15: Бодлогын орон зай, манлайллыг хүндэтгэх

ТХЗ 17.16: ТХЗ-ын хамтын ажиллагаа

ТХЗ 17.18: Найдвартай тоон мэдээллийн хүртээмж

ТХЗ 17.19: Статистикийн чадавх.

Эдгээр зорилтууд нь уялдаагүй гэж үнэлэгдсэн. Иймд, уялдаагүй, агуулгаараа уялдсан зорилтуудын төлөвлөлтийг дахин нарийвчилж, орхигдсон зорилтуудын хүрээг тодорхойлж, учир шалтгааныг судалж, дараа дараагийн батлагдах дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт гүйцээж, тусгах талаар анхаарах шаардлагатай байна.

- Уялдааны шинжилгээнээс харахад өлсгөлөнг зогсоох, сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэхтэй холбоотой зорилтууд үндэсний хөгжлийн бодлогын баримт бичигтэй илүү сайн уялдаатай байна. Цаашид, эдгээр зорилтуудын хэрэгжилтийг бүрэн хангах, шаардлагатай санхүүжилтийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах хэрэгтэй.



- Уялдаагүй болон агуулгаараа уялдсан зорилуудын тухайд, **хэт ерөнхий** байдлаар томъёолсон байгаа нь зорилт, зорилтын хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийн хоорондын уялдаа нь тодорхойгүй байсан. Иймд, дараа дараагийн батлагдах хөгжлийн бодлогын баримт бичигт уялдааны түвшинг ахиулах чиглэлээр анхаарах хэрэгтэй байна.
- Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийн төлөвлөлт нь өөрөө онцлог шинжтэй. Тухайлбал, “Ядуурал” гэдэг үг аливаа баримт бичигт бага ашиглагдсан хэдий ч ядуурлын олон хэлбэрийг бууруулах, дундаж давхаргыг нэмэгдүүлэхэд чиглэлээр маш олон бодлогын зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Тухайлбал, хүн амын орлого, ажлыг байрыг нэмэгдүүлэх, нийгмийн халамжийг сайжруулах, хоол, тэжээлийг хомсдолыг арилгах, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ болон амьдрах орчныг сайжруулах олон зорилтуудыг төлөвлөсөн байна.
